

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/30/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Батцэцэг Утас: 261628 Цахим хаяг: battsetseqp@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Төсөл, түүний үйл ажиллагаа	12
3.2 Төслийн гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Албан шаардлага	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
ТУХ	Төслийн удирдах хороо
САГ	Санхүүгийн аудитын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
МАА	Мал аж ахуй
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
УИХ	Улсын их хурал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.02 № 061922

танай _____-ны № _____-т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НЭГДСЭН
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Ж.ТҮВШИНСАНАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэх, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 3,408,970.5 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал, 2,858,439.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын Үнэн ба зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Гадаад зээл, тусламжийн төслүүдийн үр ашиг, бүтээмжийг сайжруулах хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 24 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын 7.8-д гадаад зээл, тусламжийн төслүүдийг эрэмбэлэх, хэрэгжилт, ашиглалтыг сайжруулах, төслийн менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулж, тусгайлсан төслийн нэгжүүдийг Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалтад шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төслийн “Шинэлэг шийдэл” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан Мал аж ахуйн инноваци шингэсэн бүтээгдэхүүн, Бүтээмжит түншлэлийн хамтын шийдэл болон Малын тэжээлийн зангилаа төв байгуулах гэсэн 3 төрлөөр нийт 34 дэд төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагатай “Бүтээмжит түншлэлийн гэрээ” байгуулан 2023-2025 онд нийт 12,335,894.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч Монгол Улсын Их Хурлын 2024 оны 81 дүгээр тогтоолыг үндэслэн уг хөтөлбөрийг зогсоох шийдвэр гаргасан байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хугацааг нэг удаа сунгасан бөгөөд төслийн үйл ажиллагаа 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж хаагдана.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эсцийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,296,220,608.06	11,686,757,363.73
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,001,337,052.13	6,839,572,857.74
311	Кассад байгаа бэлэн мөнгө	-	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,001,337,052.13	6,839,572,857.74
31210	Төгрөг	1,104,327,140.27	2,019,009,090.66
31211	Төрийн сангийн харилцах	1,104,327,140.27	2,019,009,090.66
31220	Гадаад валют	5,897,009,911.86	4,820,563,767.08
31221	Монгол банкин дахь харилцах	5,897,009,911.86	4,820,563,767.08
33	АВЛАГА	240,000.00	-
33500	Бусад авлага	-	-
33510	Байгууллагаас авах авлага	240,000.00	-
34	УРЬДЧИЛГАА	3,408,970,441.48	4,847,184,505.99
34600	Урьдчилж гарсан зардал	3,408,970,441.48	4,847,184,505.99
35	БАРАА МАТЕРИАЛ	1,885,673,114.45	-
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	1,885,673,114.45	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	312,063,477.04	255,838,750.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	312,063,477.04	255,838,750.00
39200	Биет хөрөнгө	306,132,786.06	255,838,750.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	497,300,000.00	497,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(191,731,250.00)	(241,461,250.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компютер)	94,864,165.00	94,864,165.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(94,300,128.94)	(94,864,165.00)
39300	Биет бус хөрөнгө	5,930,690.98	-
39301	Програм хангамж	266,255,627.00	266,255,627.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(260,324,936.02)	(266,255,627.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,608,284,085.10	11,942,596,113.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	447,699,049.94	2,858,439,811.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	447,699,049.94	2,858,439,811.20
41300	Өглөг	447,699,049.94	2,858,439,811.20
41310	Ажиллагсадтай холбоотой өглөг	240,000.00	-
41360	Бусад өглөг	447,459,049.94	2,858,439,811.20
41361	Байгууллагад төлөх өглөг	447,459,049.94	2,858,439,811.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,160,585,035.16	9,084,156,302.53
51	Засгийн газрын хувь оролцоо	12,160,585,035.16	9,084,156,302.53
51200	Хуримтлагдсан үр дүн	12,160,585,035.16	9,084,156,302.53
51210	Өмнөх үеийн үр дүн	10,377,301,999.88	12,160,585,035.16
51220	Тайлант үеийн үр дүн	1,783,283,035.28	(3,076,428,732.63)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,608,284,085.10	11,942,596,113.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН (I)	14,669,604,472.76	6,679,145,670.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,669,604,472.76	6,679,145,670.81
120	Нийтлэг татварын бус орлого	14,669,604,472.76	6,679,145,670.81
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	14,669,604,472.76	6,679,145,670.81
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,669,604,472.76	6,679,145,670.81
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,424,227,351.71	7,217,431,796.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,410,422,576.71	3,506,411,264.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,410,422,576.71	3,506,411,264.63
2101	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	608,996,745.02	667,924,636.26
210101	Үндсэн цалин	608,996,745.02	667,924,636.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,124,593.13	83,496,850.00
210201	Тэтгэврийн даатгал	52,530,893.13	56,256,850.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,898,400.00	6,810,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,949,200.00	3,405,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,949,200.00	3,405,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,796,900.00	13,620,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,086,480.18	78,240,000.00
210302	Байрны түрээс	69,086,480.18	78,240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,629,067.57	22,252,997.93
210401	Бичиг хэрэг	4,392,500.00	5,823,945.00
210402	Тээвэр, шатахуун	4,400,000.00	8,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,240,651.57	6,030,883.93
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	4,595,916.00	1,498,169.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,420,900.00	21,680,717.42
210604	Урсгал засвар	11,420,900.00	21,680,717.42
2107	Томилолт, зочны зардал	62,503,000.00	112,718,205.58
210701	Гадаад албан томилолт	-	6,678,205.58
210702	Дотоод албан томилолт	62,503,000.00	106,040,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,418,445,342.64	2,463,873,130.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,394,494,196.03	2,433,432,029.40
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	14,400,000.00	20,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	8,549,760.00	8,613,912.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	491,572.00	1,619,616.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	509,814.61	207,573.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,216,448.17	56,224,727.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,508,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	139,708,448.17	56,224,727.04
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,804,775.00	3,711,020,532.02
2200	Дотоод эх үүсвэрээр	13,804,775.00	3,711,020,532.02
221001	Их засвар	13,804,775.00	390,020,532.02
223001	Бусад хөрөнгө	-	3,321,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,245,377,121.05	(538,286,125.84)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	379,293,779.12

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	379,293,779.12
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	462,094,085.77	2,917,436,385.81
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	14,635,035.83	58,996,574.71
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	447,459,049.94	2,858,439,811.10
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,783,283,035.28	(3,076,428,732.53)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ҮР ДҮН (I)	14,670,206,472.76	6,679,145,670.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,670,206,472.76	6,679,145,670.81
120	Нийтлэг татварын бус орлого	14,670,206,472.76	6,679,145,670.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,670,206,472.76	6,679,145,670.81
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,669,604,472.76	6,679,145,670.81
120009	Бусад орлого	602,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	12,270,714,128.54	3,450,186,537.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,270,714,128.54	3,450,186,537.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,270,714,128.54	3,450,186,537.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608,996,745.03	667,924,636.26
210101	Үндсэн цалин	608,996,745.03	667,924,636.26
2102	Ажил олгогчоос НД-д төлсөн шимтгэл	76,124,593.13	83,496,850.00
210201	Тэтгэврийн даатгал	52,530,893.13	56,256,850.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,898,400.00	6,810,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,949,200.00	3,405,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,949,200.00	3,405,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,796,900.00	13,620,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,086,480.18	78,240,000.00
210302	Байрны түрээс	69,086,480.18	78,240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,629,067.57	22,252,997.93
210401	Бичиг хэрэг	4,392,500.00	5,823,945.00
210402	Тээвэр, шатахуун	4,400,000.00	8,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,240,651.57	6,030,883.93
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	4,595,916.00	1,498,169.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,420,900.00	21,680,717.42
210604	Урсгал засвар	11,420,900.00	21,680,717.42
2107	Томилолт, зочны зардал	62,503,000.00	112,718,205.58
210701	Гадаад албан томилолт	-	6,678,205.58
210702	Дотоод албан томилолт	62,503,000.00	106,040,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,418,445,342.63	2,463,873,130.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,395,004,010.63	2,433,432,029.40
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	14,400,000.00	20,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	8,549,760.00	8,613,912.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	491,572.00	1,619,616.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	207,573.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,508,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,508,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,399,492,344.22	3,228,959,133.22
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,578,538,279.05	3,711,020,532.02
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,578,538,279.05	3,711,020,532.02

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2200	Дотоод эх үүсвэрээр	1,578,538,279.05	3,711,020,532.02
221001	Их засвар	1,578,538,279.05	390,020,532.02
223001	Бусад хөрөнгө	-	3,321,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,578,538,279.05)	(3,711,020,532.02)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(14,635,035.83)	320,297,204.41
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	14,635,035.83	320,297,204.41
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	14,635,035.83	320,297,204.41
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	806,319,029.34	(161,764,194.39)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,195,018,022.79	7,001,337,052.13
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,001,337,052.13	6,839,572,857.74

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	10,377,301,999.88	10,377,301,999.88
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	10,377,301,999.88	10,377,301,999.88
9	Тайлант үеийн үр дүн			1,783,283,035.28	1,783,283,035.28
10	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	12,160,585,035.16	12,160,585,035.16
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	12,160,585,035.16	12,160,585,035.16
19	Тайлант үеийн үр дүн			(3,076,428,732.63)	(3,076,428,732.63)
20	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	9,084,156,302.53	9,084,156,302.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,611,610,000.00	6,679,145,670.81	932,464,329.19	87.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,611,610,000.00	6,679,145,670.81	932,464,329.19	87.7
122004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	7,611,610,000.00	6,679,145,670.81	932,464,329.19	87.7
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,611,610,000.00	6,679,145,670.81	932,464,329.19	87.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,611,610,000.00	7,161,207,069.61	450,402,930.39	94.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,835,610,000.00	3,450,186,537.59	385,423,462.41	90.0
210	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,835,610,000.00	3,450,186,537.59	385,423,462.41	90.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,000,000.00	667,924,636.26	13,075,363.74	98.1
210101	Үндсэн цалин	681,000,000.00	667,924,636.26	13,075,363.74	98.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,125,000.00	83,496,850.00	1,628,150.00	98.1
210201	Тэтгэврийн даатгал	57,885,000.00	56,256,850.00	1,628,150.00	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,810,000.00	6,810,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,405,000.00	3,405,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,405,000.00	3,405,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,620,000.00	13,620,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,620,000.00	78,240,000.00	1,380,000.00	98.3
210304	Байрны түрээс	79,620,000.00	78,240,000.00	1,380,000.00	98.3
2104	Хангамж, бараа материалын зардал	24,265,000.00	22,252,997.93	2,012,002.07	91.7
210401	Бичиг хэрэг	7,790,000.00	5,823,945.00	1,966,055.00	74.8
210402	Тээвэр шатахуун	8,900,000.00	8,900,000.00	0.00	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,075,000.00	6,030,883.93	44,116.07	99.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,498,169.00	1,831.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,250,000.00	21,680,717.42	569,282.58	97.4
210604	Урсгал засвар	22,250,000.00	21,680,717.42	569,282.58	97.4
2107	Томилолт, зочны зардал	129,800,000.00	112,718,205.58	17,081,794.42	86.8
210701	Гадаад албан томилолт	6,700,000.00	6,678,205.58	21,794.42	99.7
210702	Дотоод албан томилолт	123,100,000.00	106,040,000.00	17,060,000.00	86.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,813,550,000.00	2,463,873,130.40	349,676,869.60	87.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,813,550,000.00	2,463,873,130.40	349,676,869.60	87.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,776,000,000.00	3,711,020,532.02	64,979,467.98	98.3
2200	Дотоод эх үүсвэрээр	3,776,000,000.00	3,711,020,532.02	64,979,467.98	98.3
221001	Их засвар	455,000,000.00	390,020,532.02	64,979,467.98	85.7
223001	Бусад хөрөнгө	3,321,000,000.00	3,321,000,000.00	-	100.0

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	(161,764,194.39)		-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,001,337,052.13	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,839,572,857.74	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14	14	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсөл, түүний үйл ажиллагаа

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь алслагдсан сумын малчид, малчдын бүлэг, эмэгтэйчүүд, залуучууд, түүнчлэн жижиг, дунд үйлдвэрүүд болон бусад оролцогчдод чиглэж байгаа ба тэдгээрийг мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээнд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэн хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих замаар төслийн тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.

Төслийн зорилго нь мал сүргийн эрүүл мэнд, ашиг шим, нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай, үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд оршино.

Төсөл нь дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

1. Малын эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх;
2. МАА-н нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх;
3. Төслийн хэрэгжилтийг дэмжих;
4. Болзошгүй онцгой нөхцөл, гамшгийн үед хариу арга хэмжээ авах;

Төслийн зорилтот үр дүн:

1. Малын гоц халдварт өвчний тохиолдлыг 10 хувиар бууруулах;
2. Мах ба сүүний гарцыг 10 хувиар нэмэгдүүлэх;
3. Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнийг 20 хувиар нэмэгдүүлэх;

3.2 Төслийн гадаад, дотоод орчин

Тус төсөл нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”
- Сангийн сайдын 2025 оны 174 дүгээр тушаалаар баталсан “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үнэллээ.

Тайлант онд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд Дэлхийн банкны явцын хяналтууд хийгдэж, харъяа яамны хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас 2023-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд нэг удаа шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн өдөр тутмын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд МУЗГ болон Олон улсын хөгжлийн Ассоциацийн хоорондын байгуулсан санхүүжилтын хэлэлцээрийн хавсралт Төсөл хэрэгжүүлэх заавар, санхүүгийн удирдлагын гарын авлага, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмыг мөрддөг бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 665,688.0 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,001,337.1	6,839,572.9	(161,764.2)
Авлага	240.0	-	(240.0)
Урьдчилж гарсан зардал	3,408,970.4	4,847,184.5	1,438,214.1
Бараа материал	1,885,673.1	-	(1,885,673.1)
Үндсэн хөрөнгө	306,132.8	255,838.7	(50,294.1)
Биет бус хөрөнгө	5,930.7	-	5,930.7
Нийт хөрөнгө	12,608,284.1	11,942,596.1	(665,688.0)
Богино хугацаат өр төлбөр	447,669.1	2,858,439.8	2,410,770.7
Хуримтлагдсан үр дүн	12,160,585.0	9,084,156.3	(3,076,428.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,608,284.1	11,942,596.1	(665,688.0)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,839,572.9 мянган төгрөг болж, 161,764.2 мянган төгрөгөөр буурсан нь барилгын засварын ажил гүйцэтгэх гэрээний чанарын баталгааны 5 хувийн төлбөрийг төлсөнтэй холбоотой;

Өмнөх онуудад хийгдсэн лабораторийн засварын ажилд олгосон 1,438,214.1 мянган төгрөгийн санхүүжилтийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлуулан бүртгэснийг урьдчилж гарсан зардал данс руу залруулснаар нэмэгдсэн;

Бараа материалын данс 1,885,673.1 мянган төгрөгөөр буурсан нь 447,459.0 мянган төгрөгийн засварын ажил гүйцэтгэх гэрээний үлдэгдэл төлбөрийг төлсөн, дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 1,438,214.1 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардал данс руу залруулж бичсэн нь нөлөөлсөн;

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 2,858,439.8 мянган төгрөг болж, 2,410,770.7 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалтын гэрээний төлбөр, бүтээмжит түншлэлийн 6 дэд төслийн гэрээний гүйцэтгэлийг бүртгэсэн, гэрээний төлбөрийг 223,100.0 мянган төгрөгөөр илүү бүртгэснийг залруулсантай холбоотой;

Хуримтлагдсан үр дүнгийн данс тайлант оны санхүүгийн үр дүн 3,076,428.7 мянган төгрөгөөр буурсан байна;

Төслийн нягтлан бодох бүртгэлд “Файнанс систем” санхүүгийн программ ашиглаж, төсвийн гүйцэтгэлийг төгрөгөөр, дэлхийн банкны санхүүжилтийн зарцуулалтыг ам.доллараар мөнгөн сууриар бүртгэж тайлагнадаг. Бүртгэлийн аккрузель суурийг мөрдөхөд хүндрэл гардаг учир хөгжүүлэлтийг байнга хийж, шинэчлэх шаардлага үүсдэг.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх гадаад зээлийн эх үүсвэрийг 22,907,851.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсний зардал 94,506.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 11,551.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 19,060.0 мянган төгрөг, хангамж, томилолтын зардлыг 77,800.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний төлбөр хураамж 7,476,627.9 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 1,790,800.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 235,775.9 мянган төгрөгөөр тус тус бууруулж, хангамж бараа материалын зардлыг 2,086.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 13,203,815.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Сангийн яамнаас 2024 оны 01/10803 дугаар албан тоотоор УИХ-ын 2024 оны 54 дүгээр тогтоолын дагуу гадаадын зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал зэрэг урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх чиглэл ирүүлснээс шалтгаалсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг 13,203,815.3 мянган төгрөгөөр гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаадын эх үүсвэрээс 7,611,610.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Нийт зардлын гүйцэтгэл 7,161,207.1 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын зардал 14,702.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,380.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 2,012.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 569.3 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 17,081.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 349,676.9 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 64,979.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70207-Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх зээл, тусламжийн хөтөлбөр	7,611,610.0	7,161,207.1	450,402.9	94.1
1.1	80104-Гадаад зээлээр хэрэгжүүлэх арга хэмжээ	7,611,610.0	7,161,207.1	450,402.9	94.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

1. Гадаад томилолтын талаар:

ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/205 тушаалаар баталсан төсвийн дагуу БНХАУ-ын Бээжин хотод Шугаман эс цидмэглэн өсгөвөрлөх технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд төслийн зохицуулагч, малын эрүүл мэндийн ажилтан нар томилолтоор ажиллаж 6,678.2 мянган төгрөг зарцуулсан;

2. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:

Тайлант онд Өгөгдөлд суурилсан бизнесийн ухаалаг шийдэл-төслийн удирдлага сургалт, Мэргэжлийн болон техникийн мэдлэг дээшлүүлэх сургалт, Малын эмч нарт зориулсан сургалт-Увс, Өвөрхангай аймагт, Шинэлэг шийдэл хөтөлбөрийн арга хэмжээ, Атрын дөрөвдүгээр аян-технологийн долоо хоног нэгдсэн арга хэмжээ тус бүр нэг нэг хүн хамрагдаж 44,175.9 мянган төгрөг зарцуулсан;

3. Программ хангамжийн бүртгэл, тайлагналын талаар:

Төслийн нэгж нь 266,255.6 мянган төгрөгийн өртөгтэй Файнанс систем санхүүгийн программ хангамжийг үйл ажиллагаандаа ашигладаг байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл нь Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дундговь, Говь-Алтай, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Төв, Увс, Өвөрхангай, Завхан зэрэг зорилтот 12 аймгийн 80 сум болон Улаанбаатар хотын бүс нутгуудад малын зонхилон тохиолдох өвчний тархалтын бууралт, малын гаралтай бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх, түүний үнэ цэнийн өсөлтийг бий болгох чиглэлээр хэрэгжиж байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган ам.доллар/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Малын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах	2020.06.30 2026.03.31	100	87.7	8,500.0	7,454.0
1.1	Байгууллагын болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх		100	73.7	2,500.0	1,842.2
1.2	Малын өвчний тандалт, хяналт, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах		100	101.0	5,000.0	5,049.7
1.3	Салбарын цахим үйлчилгээг сайжруулах		100	56.2	1,000.0	562.1
2	Өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлт		100	64.6	6,500.0	4,198.1
2.1	Мал сүргийн бүтээмжийг нэмэгдүүлэх		100	57.7	2,000.0	1,154.5
2.2	Бүтээмжит түншлэл		100	67.6	4,500.0	3,043.6
3	Төслийн хэрэгжилтийг дэмжих		100	92.5	2,000.0	1,850.3
4	Байгалийн гамшиг, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах		100	92.4	13,000.0	12,009.4
	Нийт				85.0	30,000.0

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

ТУХ-ны 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 2025/PSC-11/-01 дугаар тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж 19,595,276.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 10 худалдан авах ажил зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнээс 9,511,782.4 мянган төгрөгийн 8 худалдан авалтыг зохион байгуулж гэрээ байгуулснаас барааг хугацаандаа нийлүүлэх боломжгүй болсон 2,932,000.0 мянган төгрөгийн 2 гэрээ, Дэлхийн банкнаас эрсдэлтэй гэж үзэн тендер зарлагдахаас өмнө

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7,200,000.0 мянган төгрөгийн 1 худалдан авалтыг тус тус цуцалсан, 2,520,000.0 мянган төгрөгийн 1 худалдан авалтын тендер амжилтгүй болсон байна.

Хүснэгт 4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

/мянган төгрөг/

№	Худалдан авалт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл			Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн
1	Бараа	5	8,960,000.0	5	8,596,900.0	100.0	-	363,100.0
2	Ажил	1	7,200,000.0	-	-	-	1	7,200,000.0
3	Үйлчилгээ	4	3,435,276.1	3	914,882.4	75.0	1	2,520,393.7
Дүн		10	19,595,276.1	8	9,511,782.4	80.0	2	10,083,493.7

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ди Эй Би Жи Аудит” ХХК-ийн аудитор Э.Цэрэннадмид гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Батцэцэг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 005/001 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 12,424,227.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 124,242.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлсийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 болон 15 дугаар зүйлийн 15.1.1 - 15.1.8 дахь заалтуудад заасан хуулиар хориглох зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 23 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих нийт 166 мэдээллээс Байгууллагын батлагдсан төсөв, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл зэрэг 9 мэдээг хугацаа хоцрож мэдээлсэн. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

бүхий 2 удаагийн 18,438.4 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг мэдээлээгүй, мэдээлсэн байдал 92.8 хувь, хугацаа хоцролт 95.0 хувь байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,210,360.3 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс 9,475,831.9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 3,474,956.6 мянган төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага, 6,259,571.8 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлснээс хэрэгжилтийн биелэлт 86.0 хувь байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Дд	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	4	9,475,831.9	2	5,622,496.6	62.0
2	Хариуцлага тооцох албан шаардлага	1	3,474,956.6	1	3,474,956.6	100.0
3	Зөвлөмж	3	6,259,571.8	3	6,259,571.8	97.0
Нийт дүн		8	19,210,360.3	6	15,357,025.0	86.0

Санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардал, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан 2 асуудлаар өгсөн өмнөх аудитын албан шаардлага хэрэгжээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төслийн хэрэгжих хугацаа 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр хаагдаж байгаа тул төслийн санхүүгийн хаалтын үйл ажиллагаа, Монгол Улсын Засгийн газрын зээлийн ашиглалтын тооцоо, бэлтгэн нийлүүлэгч байгууллага, хувь зөвлөхүүдийн гэрээний хэрэгжилтийн бүртгэлийг дараагийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,661,314.1 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

1. Дансны өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлээрх байгууллагад төлөх өглөг 2,858,439.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд 3,081,539.8 мянган төгрөгөөр буюу 223,100.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь УСНББОУС 29.45 "Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр илэрхийлээгүй тохиолдолд, анх удаа хүлээн зөвшөөрөх үедээ байгууллага хөрөнгө ба өр төлбөрийг гаргахад эсвэл худалдан авахад шууд хамаарах ажил гүйлгээний зардлыг нэмсэн бодит үнэ цэнээр хэмжих ёстой", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцээгүй, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
2. Өмнөх онуудад хийгдсэн лабораторийн засварын ажилд олгосон санхүүжилтийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлуулан бүртгэж 1,438,214.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь УСНББОУС 28.9 "Санхүүгийн хэрэглүүр гэдэг нь нэг байгууллагын санхүүгийн хөрөнгө болон нөгөө байгууллагын санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр хоёрыг аль алиныг үүсгэх гэрээ юм", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаал "Гадаад зээлийн хөрөнгийн ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 9.2.30-д "Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад гадаад зээлийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж болон их засварын ажлыг тэдгээрийг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийг хүлээн авсан гүйцэтгэлийн дүнгээр тус тус хөрөнгийн бүртгэлд бүртгэж, санхүүгийн тайландаа тусгана" гэсэнтэй тус тус нийцээгүй, ангилал, үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангаагүй;

Аудитаар нийт 6,267,410.3 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд 6,267,410.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 6,267,410.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,143,168.0 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Өмнөх аудитаар өгсөн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 602/A0150069, 603/A0150069 дугаартай албан шаардлагуудыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан. Санхүүгийн тайланд 3,480,970.5 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал, 2,858,439.8 мянган төгрөгийн дансны өглөг, нийт 6,267,410.3 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй, үнэн ба зөв, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд тусгасан урьдчилж гарсан зардал, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Дансны өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлээрх байгууллагад төлөх өглөг 2,858,439.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд 3,081,539.8 мянган төгрөгөөр буюу 223,100.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	223,100.0			1	223,100.0	1	223,100.0				
2	Өмнөх онуудад хийгдсэн лабораторийн засварын ажилд олгосон санхүүжилтийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлуулан бүртгэж 1,438,214.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан	1	1,438,214.1			1	1,438,214.1	1	1,438,214.1				
Дүн		2	1,661,314.1			1	1,661,314.1	-	1,661,314.1	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал			
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага					
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайланд 3,480,970.4 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал, 2,858,439.8 мянган төгрөгийн дансны өглөг, нийт 6,267,410.3 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан байна	1	6,267,410.3			1	6,267,410.3								
Дүн		1	6,267,410.3			1	6,267,410.3								



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1175 /А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/30/НА - СТА - ТХМ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 602/А0150069, 603/А0150069 дугаартай албан шаардлагуудыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан. Санхүүгийн тайланд 3,408,970,441.48 /гурван тэрбум дөрвөн зуун найман сая есөн зуун далан мянга дөрвөн зуун дөчин нэгэн төгрөг дөчин найман мөнгө/-ийн урьдчилж гарсан зардал, 2,858,439,811.20 /хоёр тэрбум найман зуун тавин найман сая дөрвөн зуун гучин есөн мянга найман зуун арван нэгэн төгрөг хорин мөнгө/-ийн дансны өглөг, нийт 6,267,410,252.68 /зургаан тэрбум хоёр зуун жаран долоон сая дөрвөн зуун арван мянга хоёр зуун тавин хоёр төгрөг жаран найман мөнгө/-ийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн захирал /Ц.Болорчулуун/, санхүүгийн ажилтан /З.Ариунцэцэг/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-41.Docx

1526181826